



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/174/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.17 № 126

тантай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улиастай сумын Хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улиастай сумын Хүүхдийн 8 дугаар цэцэрлэг нь хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 19,859.8 мянган төгрөгийн компьютер, бусад хандив тусламжаар ирсэн, нийт 21,199.9 мянган төгрөгийн хөрөнгө, тусгай зориулалттай материалыг данс бүртгэлд тусгажээ. Тус цэцэрлэг нь 4212 м.кв газрыг боловсролын чиглэлээр 15 жил эзэмшихээр гэрчилгээжүүлж, бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Улиастай сумын Хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 10 нэр төрлийн 3,231.0 мянган төгрөгийн хангамжийн материалыг залруулж холбогдох дансанд бүртгээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Улиастай сумын Хүүхдийн 8 дугаар цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 56 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 99 хувьтай байна. Тайлант онд өмнөх оны 2,217.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан ч, гурван байгууллагад 5,066.8 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Diisk/Арбан бичиг/Дүгнэлт

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


Д.БАТ-УНДРАА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	146,814,592.38	136,637,724.83
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	72,032,433.12	58,849,440.25
8	Банкинд байгаа бэлэн мөнгө		
16	Гадаад валютаар	(0.00)	(0.00)
17	Төрийн сангийн харилцах	72,032,433.12	58,849,440.25
27	АВЛАГА	2,217,605.07	-
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	2,217,605.07-	-
29	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
34	Бусад авлага	-	-
35	Байгууллагаас авах авлага	-	-
60	БАРАА МАТЕРИАЛ	72,564,554.19	77,788,284.58
61	Түүхий эд материал	994,100.00	4,743,200.00
62			3,806,200.00
63	Эм боох материал	994,100.00	937,000.00
66	Хангамжийн материал	71,570,454.19	73,045,084.58
67	Бичиг хэргийн материал	892,950.00	948,000.00
68	Аж ахуйн материал	45,570,459.48	46,100,459.48
70	Түлш шатах тослох материал	4,905,002.11	6,120,000.00
71	Барилгын засварын материал	124,000.00	124,000.00
72	Хүнсний материал	2,458,580.00	1,851,102.50
73	Бусад хангамжийн материал	17,619,462.60	17,901,462.60
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	310,795,151.18	315,931,469.01
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	310,795,151.18	315,931,469.01
108	Биет хөрөнгө	292,189,651.18	297,655,969.01
109	Барилга, байгууламж	266,626,811.90	266,626,811.90
110	Хуримтлагдсан элэгдэл	-29,488,119.78	-34,165,432.98
111	Авто тээврийн хэрэгсэл	-	-
112	Машин, тоног төхөөрөмж	102,090,544.77	122,280,294.77
113	Хуримтлагдсан элэгдэл	-71,538,684.60	-79,793,371.56
114	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,604,346.72	20,034,346.72
115	Хуримтлагдсан элэгдэл	-10,996,672.47	-12,019,179.89
116	Бусад үндсэн хөрөнгө	19,674,020.00	19,674,020.00
122	Хуримтлагдсан элэгдэл	-4,725,105.36	-5,924,019.95
123	Ном	942,500.00	942,500.00
126	Биет бус хөрөнгө	18,605,000.00	18,275,500.00
127	Програм хангамж	1,850,000.00	1,850,000.00
128	Хуримтлагдсан элэгдэл	-1,217,500.00	-1,547,500.00
129	Бусад биет бус хөрөнгө	17,973,000.00	17,973,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	457,609,743.56	452,569,193.84
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	5,318,225.00	5,066,851.00
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,318,225.00	5,066,851.00
164	Өглөг	5,318,225.00	5,066,851.00
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	(0.00)	-

170	Бусад өглөг		
171	Байгууллагад төлөх өглөг	5,318,225.00	5,066,851.00
172	Хувь хүмүст төлөх өглөг		
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	452,291,518.56	447,502,342.84
215	Засгийн газрын хувь оролцоо	452,291,518.56	447,502,342.84
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	676,027,021.18	676,027,021.18
217	Өмч: -Төрийн өмч		
223	Хуримтлагдсан үр дүн	-227,659,092.78	-232,448,268.50
224	Өмнөх үеийн үр дүн	-227,659,092.78	-227,659,092.78
225	Тайлант үеийн үр дүн		-4,789,175.72
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,923,590.16	3,923,590.16
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	457,609,743.56	452,569,193.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	578,636,255.93	670,981,240.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,636,955.93	21,199,940.00
77	Нийтлэг татварын бус орлого	22,636,955.93	21,199,940.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого-Үндсэн хөрөнгө		20,619,740.00
82	Үндсэн үйл ажиллагааны орлого- Бараа материал	2,586,955.93	580,200.00
86	Бусаад орлого	20,050,000.00	
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	555,999,300.00	649,781,300.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	520,850,700.00	603,050,500.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	520,850,700.00	603,050,500.00
114	Орон нутгийн төсвийн санхүүжилт	35,148,600.00	46,730,800.00
115	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/ орон нутгийн төсөвт байгууллага/	35,148,600.00	46,730,800.00
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	-	-
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас	-	-
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	517,907,829.33	675,770,415.72
148	УРСГАЛ ЗАРДАЛ	517,907,829.33	675,770,415.72
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	516,403,983.48	662,680,249.56
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	361,505,176.44	478,301,626.26
151	Цалин	258,441,774.52	343,312,880.21
152	Нэмэгдэл цалин	87,025,146.97	126,222,669.14
153	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
154	Урамшуулал	16,038,254.95	8,766,056.91
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,909,783.68	59,948,702.68
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	32,283,755.05	40,452,502.68
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,731,987.38	4,874,100.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,976,789.92	2,437,000.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	711,129.79	2,437,000.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,206,121.54	9,748,100.00
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,212,306.15	29,672,235.95
165	Гэрэл цахилгааны зардал	6,691,204.15	6,621,163.84
166	Түлш, халаалтын зардал	10,839,662.00	16,305,102.11
167	Цэвэр, бохир усны зардал	10,681,440.00	6,745,970.00
170	Хангамж, бараа материалын зардал	2,008,750.00	

171	Бичиг хэргийн материал	15,250.00	
172	Тээвэр, шатахууны зардал	-	-
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	-	-
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	-
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,993,500.00	-
178	Бараа материал актасны зардал	-	-
181	Нормативт зардал	57,017,485.00	62,111,302.50
182	Эм		57,100.00
183	Хоол	57,017,485.00	62,054,202.50
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
185	Эд хогшил, урсгал засварын зардал	2,907,100.00	2,419,270.00
188	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	-
189	Урсгал засвар	2,907,100.00	2,419,270.00
190	Томилолт, зочны зардал	-	-
192	Дотоод томилолтын зардал	-	-
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,113,909.64	1,546,390.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	-
198	Тээврийн хэрэгслийн татвар	-	-
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,113,909.64	1,546,390.00
201	Газрын төлбөр	-	-
209	Бараа үйлчилгээний бусад зардал	16,729,472.57	28,680,742.17
210	Бараа үйлчилгээний бусад зардал	5,534,000.00	8,687,870.00
211	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	438,300.00	4,509,450.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,757,172.57	15,483,422.17
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,503,845.85	13,090,166.16
228	Бусад урсгал шилжүүлэг	-	-
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	-
269	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	60,728,426.60	-4,789,175.72
277	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
278	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
288	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	()
289	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	60,728,426.60	-4,789,175.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	576,049,300.00	649,781,300.00
78	Нийтлэг татварын бус орлого	20,050,000.00	
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	20,050,000.00	
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	555,999,300.00	649,781,300.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	520,850,700.00	603,050,500.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	520,850,700.00	603,050,500.00
113	Орон нутгийн төсвийн санхүүжилт	35,148,600.00	46,730,800.00
114	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/ орон нутгийн төсөвт байгууллага/	35,148,600.00	46,730,800.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	504,374,964.83	662,964,292.87
148	УРСГАЛ ЗАРДАЛ	504,374,964.83	662,964,292.87
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	502,871,118.98	649,874,126.71

150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	363,696,672.36	476,084,001.19
151	Үндсэн цалин	257,946,887.00	341,095,275.14
152	Нэмэгдэл	90,196,461.58	126,222,669.14
153	Унаа хоолны хөнгөлөлт		
154	Үр дүнгийн урамшуулал	15,553,323.78	8,766,056.9
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	46,935,892.83	59,948,702.68
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	31,888,417.63	40,452,502.68
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,812,073.87	4,874,100.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,056,258.35	2,437,000.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	768,255.20	2,437,000.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,410,887.78	9,748,100.00
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	30,891,354.15	30,887,233.84
165	Гэрэл цахилгааны зардал	5,697,664.39	6,621,163.84
166	Түлш, халаалтын зардал	14,008,889.76	17,520,100.00
167	Цэвэр, бохир усны зардал	11,184,800.00	6,745,970.00
170	Хангамж, бараа материалын зардал		
171	Бичиг хэрэг		
172	Тээвэр, шатахуун		
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
181	Нормативт зардал	48,205,000.00	61,698,099.00
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
183	Хоол, хүнс	48,205,000.00	61,698,099.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
185	Эд хогшил, урсгал засварын зардал	2,753,400.00	2,753,400.00
186	Багаж техник хэрэгсэл		
188	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл		
189	Урсгал засвар	2,753,400.00	2,753,400.00
190	Томилолт, зочны зардал		
192	Дотоод албан томилолт		
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	834,300.00	1,546,390.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж		
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
198	Тээврийн хэрэгслийн татвар		
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	834,300.00	1,546,390.00
201	Газрын төлбөр		
203	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
204	Бараа үйлчилгээний бусад зардал	7,051,499.64	11,652,900.00
205	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,503,000.00	5,303,400.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,503,845.85	13,090,166.16
225	Бусад урсгал шилжүүлэг		
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		
234	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,503,845.85	13,090,166.16
235	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,503,845.85	13,090,166.16
251	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	71,674,335.17	-13,182,992.87
252	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

262	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	22,580,000.00	
263	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,580,000.00	
264	Дотоод эх үүсвэрээр	22,580,000.00	
276	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,580,000.00	
279	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-22,580,000.00	
280	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
304	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	49,094,335.17	-13,182,992.87
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,938,097.95	72,032,433.12
306	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	72,032,433.12	58,849,440.25

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	676,027,021.18	3,923,590.16	-227,659,092.78	452,291,518.56
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	676,027,021.18	3,923,590.16	-227,659,092.78	452,291,518.56
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	676,027,021.18	3,923,590.16	-227,659,092.78	452,291,518.56
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.0	0.0	-4,789,175.72	-4,789,175.72
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	676,027,021.18	3,923,590.16	-232,448,268.50	447,502,342.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	721,813,800.00	662,964,292.87
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	721,813,800.00	662,964,292.87
4	Бараа, үйлчилгээний зардал	721,813,800.00	649,874,126.71
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	529,225,700.00	476,084,001.19
6	Үндсэн цалин	382,246,000.00	341,095,275.14
7	Нэмэгдэл	135,579,000.00	126,222,669.14
8	Унаа, болон бусад нөхөн олговор		
9	Урамшуулал	11,400,700.00	8,766,056.91
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,605,500.00	59,948,702.68
12	Тэтгэврийн даатгал	42,573,300.00	40,452,502.68
13	Тэтгэмжийн даатгал	5,007,700.00	4,874,100.00
14	ҮОМШӨ ний даатгал	2,504,200.00	2,437,000.00
15	Ажилгүйдлийн даатгал	2,504,200.00	2,437,000.00
16	Эрүүл мэндийн даатгал	10,017,100.00	9,748,100.00
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,977,400.00	30,887,233.84
18	Гэрэл цахилгаан	7,199,600.00	6,621,163.84
19	Түлш, халаалт	18,231,800.00	17,520,100.00
20	Цэвэр, бохир ус	18,546,000.00	6,745,970.00
30	Нормативт зардал	62,975,700.00	61,698,099.00

32	Хоол, хүнс	62,975,700.00	61,698,099.00
38	Урсгал засвар	2,753,500.00	2,753,500.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,705,800.00	1,546,390.00
49	Мэдээллийн технологийн зардал	1,705,800.00	1,546,390.00
52	Бараа үйлчилгээний бусад зардал	13,264,800.00	11,652,900.00
53	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,304,400.00	5,303,400.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		13,090,166.16
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	649,781,300.00	649,781,300.00
98	Улсын төвлөрсөн төсвөөс	603,050,500.00	603,050,500.00
99	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/ орон нутгийн төсөвт байгууллага/	46,730,800.00	46,730,800.00
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	24	24
134	Удирдах ажилтан	1.00	1.00
135	Гүйцэтгэх ажилтан	16	16
136	Үйлчлэх ажилтан	7	7
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улиастай сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл:

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ

Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн зорилго:

Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд "төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай", "орон нутагт ажилласны

нэмэгдлийг тооцож олгох тухай", "цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх" зэрэг Засгийн газрын тогоолуудад өөрчлөлт орсон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улиастай сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 5,040.5 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Авлага	2,217.6		-2,217.6
Бараа материал	72,564.5	77,788.2	5,223.7
Үндсэн хөрөнгө	310,795.2	315,931.5	5,136.3
Нийт хөрөнгө	457,609.7	452,569.2	-5,040.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	452,291.5	447,502.3	-4,789.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	457,609.7	452,569.2	-5,040.5

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 72,564.5 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 93,403.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 580.2 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал хандиваар ирснийг бүртгэж, 88,760.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 77,788.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,223.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд 20,619.7 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 315,931.5 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 15,483.4 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 4,789.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 721,786.7 мянган төгрөг, нийт зарлагыг 721,786.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тодотголоор нэмж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд 721,786.7 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсвөөс авч 13,090.17 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 649,874.1 мянган төгрөг буюу 90.03 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган

төгрөгөөр/

Хөтөлбөрс рга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол	675,082.9	616,233.9	58,849.0	91.2
80233	Хүүхэд хамгааллын зардал	802.8	800.0	2.8	99.65
81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	1,375.6	1,364.0	11.6	99.15
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал	62,975.7	61,698.1	277.6	97.97
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,415.2	2,415.2	0	100
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал	1,224.1	953.4	270.7	77.88
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	599,429.7	543,692.0	55,737.7	90.70
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	6,859.8	5,311.0	1,548.8	77.42
Дүн		675,082.9	616,233.9	58,849.0	91.2
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
80109		46,730.8	33,640.2	13,090.6	71.98
Нийт дүн		721,786.7	649,874.1	71,939.6	90.03

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орон нутгийн төсвөөс 46,730.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 30,887.2 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2,753.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 13,090.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Улиастай сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэг нь тайлант онд бараа ажил, үйлчилгээнд тендэр шалгаруулалт зарласан боловч худалдан авагч ороогүй тул шууд худалдан авалт хийгдсэн.

Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.5 хувиар тооцож, 7,751.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 5,813.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Уластай сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж шилэн дансны хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа тухайгаа эрхлэгчийн 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 03 тоотой ирүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татсан асуудал байгаагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,231.0 мянган төгрөгийн алдаа илэрч 3,231.0 мянган төгрөгийн зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт: тогтоогоогүй

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж: Бусад биет бус хөрөнгийн дансанд 10 нэр төрлийн 3.231.0 мянган төгрөгийн хангамжийн материал бүртгэлтэй байгаа нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хангамжийн материалыг зохих дансанд залруулан бүртгэх талаар зөвлөмж өгөв.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул **"Өөрчлөлтгүй"** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

